



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

**“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн
газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот
түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн
гэрээний биелэлтийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Т.Пүрэвхатантай байгуулсан 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Т.Пүрэвхатантай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2024 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн захирал Т.Пүрэвхатанд хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Захирал Т.Пүрэвхатанд хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээр гаргахыг “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Ц.Бат-Өлзийд зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132000604
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
183 дугаар тогтоолын хавсралт

"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛД
2024 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

д/д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг /мян.төг/	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал /мян.төг/	Урамшуулал тооцох цэвэр ашиг /мян.төг/	Олгох урамшууллын хэмжээ /мян.төг/
1	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ	Т.Пүрэвхатан	3,924,458.31	0.0	3,924,458.31	7,520.593

(долоон сая таван
зуун хорин мянга
таван зуун ерэн
гурван төгрөг)